

ПРАКТИКАЛ ДААТГАЛ  
ХЯНАВ




ПРАКТИКАЛ  
ДААТГАЛ

**“ПРАКТИКАЛ ДААТГАЛ” КОМПАНИЙН ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ,  
ЗУУЧЛАГЧИД ШИМТГЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

**ПДЖ-СБА-11 (03)**



	<b>“ПРАКТИКАЛ ДААТГАЛ” ХХК-ИЙН                  ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ,                  ЗУУЧЛАГЧИД ШИМТГЭЛ ОЛГОХ                  ЖУРАМ</b>	Код: ЦДЖ-СБА-11	Хуудас: 6
		Мөрдөж эхлэх:	2018.01.02
Танилцаж саналаа тусгасан:	1. Гүйцэтгэх захирал:	О.Гантөмөр	
	2. Даатгалын газрын захирал	Э.Баярмагнай	
	3. Нөхөн төлбөрийн албаны дарга	Л.Мэргэнсанаа	
	4. ЗХНА-ны дарга	Ч.Болор-Эрдэнэ	
	5. Бизнес хөгжлийн газрын захирал	Л.Цогт-Очир	
Боловсруулсан:	6. Санхүү бүртгэлийн албаны дарга	Б.Хишигбаяр	

**АГУУЛГА:**

- |    |        |                                |
|----|--------|--------------------------------|
| 1. | Зүйл 1 | Нийтлэг үндэслэл               |
| 2. | Зүйл 2 | Нэр томъёоны тодорхойлолт      |
| 3. | Зүйл 3 | Даатгалын төлөөлөгчийн шимтгэл |
| 4. | Зүйл 4 | Даатгалын зуучлагчийн хөлс     |
| 5. | Зүйл 5 | Тайлагнал, хариуцлага          |

**ХАВСРАЛТ:**

- |                 |                         |
|-----------------|-------------------------|
| 1. Хавсралт №01 | Шимтгэл олгох зөвшөөрөл |
|-----------------|-------------------------|

БАТЛАВ.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.ГАНТӨМӨР

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Даатгалын төлөөлөгч, зуучлагчид шимтгэл олгох журам /Цаашид “журам” гэх/ нь “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль”, СЗХорооноос баталсан “Даатгал түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ыг болон бусад холбогдох хууль, тогтоомжид үндэслэсэн “Практикал Даатгал” ХХК /цаашид “компани” гэх/-ийн баримт бичиг болно.
- 1.2. Журмын зорилго нь “Практикал Даатгал” ХХК-тай хамтран ажилладаг даатгалын төлөөлөгч, зуучлагчид даатгалын хураамжийн орлогоос шимтгэл тооцоолон олгох харилцааг зохицуулахад оршино.
- 1.3. Журамд Даатгалын газар, Санхүү бүртгэлийн албаны саналыг үндэслэн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.

### ХОЁР. НЭР ТОМЪЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1 Даатгалын үйл ажиллагаа-Даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасан үйл ажиллагааг;
- 2.2 Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа -Даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үйл ажиллагаа;
- 2.3 Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа -Даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх үйл ажиллагааг; /даатгалын төлөөлөгч нь хувь хүн болон хуулийн этгээд байж болно/
- 2.4 Даатгалын зуучлалын хөлс-Даатгалын зуучлагч болон даатгалын төлөөлөгчид даатгал зуучилсаны төлөө олгох хөлс;

### ГУРАВ. ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ШИМТГЭЛ

- 3.1 Компанийн даатгалын мэргэжилтэн, орон нутаг салбар хариуцсан захирлууд СЗХорооноос эрх авсан даатгалын төлөөлөгчтэй гэрээ байгуулж хамтран ажиллана.
- 3.2 Хариуцсан даатгалын мэргэжилтэн, салбарын захирлууд төлөөлөгчийн хувийн хэрэг, хамтран ажиллах гэрээ, олгосон шимтгэлийн баримт мэдээллийг архивлан хадгална.
- 3.3 Даатгалын төлөөлөгч шимтгэлийг
  - 3.3.1 Даатгалын төрөл
  - 3.3.2 Харилцагч байгууллагын онцлог, орлогын хэмжээ, ач холбогдлоос хамааруулан ялгаатай тогтоож болно.
- 3.4 Төлөөлөгч зуучлагчтай гэрээ байгуулахаар тохиролцох үед Даатгалын газрын захиралтай зөвшилцөн Гүйцэтгэх захирлаас зөвшөөрөл авна.
- 3.5 Шинээр даатгал хийж байгаа гэрээний хувьд шимтгэл нь бүтээгдэхүүний төрөлтэй уялдан дараах хувь хэмжээнээс хэтрэхгүй байна.
  - 3.5.1 Тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн хариуцлагын даатгал, гадаад зорчигчийн даатгалын шимтгэл -15%
  - 3.5.2 МЭД-ийн шимтгэл -15%
  - 3.5.3 Бусад даатгалын бүтээгдэхүүний шимтгэл - 20%
- 3.6 Онцгой тохиолдолд төлөөлөгчийн шимтгэлийн хэмжээг дээр дурьдсанаас өөрөөр тогтоож болох бөгөөд энэ тохиолдолд гэрээ байгуулагдахаас өмнө хамтран ажиллаж байгаа даатгалын мэргэжилтэн хавсралт №1-ийн дагуу Гүйцэтгэх захирлаас зөвшөөрөл авна.

- 3.7 Даатгалын гэрээ сунгагдан үргэлжлүүлэн даатгагдаж байгаа харилцагчийн өмнөх жилийн нөхөн төлбөрийн мэдээллээс хохирол нөхөлтийн харьцаа компанийн босго харьцаанаас дээш байвал төлөөлөгчийн шимтгэлийн хэмжээг бууруулж 3.5 заалтаас хэтрүүлэхгүй байхаар мөрдөнө.
- 3.8 Хэрэв төлөөлөгчийн шимтгэлийн хэмжээг өмнөх жилийнхээс бууруулан гэрээ байгуулсан тохиолдолд хариуцсан даатгалын мэргэжилтэнд багасгасан үнийн дүнгийн 10%-ийн борлуулалтын урамшуулал тооцож олгоно.
- 3.9 Төлөөлөгчийн шимтгэлийн хэмжээг 3.7 болон 3.8 дахь заалтаар бууруулсан тохиолдолд хамтын ажиллагааны хөтөлбөрт зориулж бууруулсан шимтгэлийн 40 хүртэлх хувийг Гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр зарцуулж болно.
- 3.10 Даатгалын төлөөлөгч нь хувь хүн бол олгох шимтгэлээс хуулийн дагуу ХХОАТ суутгасны дараа гарт олгох дүнг тооцоолж төлөөлөгчийн дансанд шилжүүлнэ.
- 3.11 Даатгалын төлөөлөгч нь хуулийн этгээд бол ХХОАТ суутгахгүйгээр төлөөлөгчийн дансанд шилжүүлнэ.

### ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИЙН ХӨЛС

- 4.1 Эрх бүхий даатгалын зуучлагчтай анх гэрээ байгуулах үед даатгалын төрлөөс хамааруулан шимтгэлийн хувь хэмжээг тохиролцон Гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдөнө.
- 4.2 Даатгалын гэрээ дараагийн жилд сунгагдан ажиллах үед даатгалын гэрээний хохирлын харьцаа дундажаас дээш болвол зуучлагчтай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу даатгалын зуучлалын хөлсийг 3.4-т заасан хувиас хэтрүүлэхгүй мөрдөнө.
- 4.3 Даатгалын зуучлагчид олгох зуучлалын хөлсөөс ХХОАТ -ыг суутгахгүй.
- 4.4 Даатгалын зуучлагчид олгох зуучлалын хөлсний тооцоог хариуцсан менежер, мэргэжилтэн сар бүр хийж даатгалын зуучлагчийн нэхэмжлэхийг СБА-д хүлээлгэн өгнө.

### ТАВ. ТАЙЛАГНАЛ, ХАРИУЦЛАГА

- 5.1 Улирал бүрийн дараа сарын 15-ны дотор даатгалын мэргэжилтнүүд хариуцсан төлөөлөгч, зуучлагч бүрээр даатгалын хураамжийн орлого, үнэлгээ, шимтгэлийн дүнг харуулсан мэдээг СЗХорооноос баталсан МАЯГТ СЗХ04118 дагуу гаргаж СБА-нд хүлээлгэн өгнө
- 5.2 Даатгагч буюу Практикал Даатгал ХХК-ийн СБАлба “Даатгал түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын дагуу улирал бүр санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгад төлөөлөгч, зуучлагчид олгосон шимтгэлийг тайлагнана.
- 5.3 СЗХ-ны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 277 дугаар тогтоолоор батлагдсан "Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам"-д заасны дагуу 20 000 000 /хорин сая/-аас дээш мөнгөн дүнтэй шимтгэл авсан төлөөлөгч зуучлагчийг нийтэд мэдээлэх үүрэг хүлээнэ.
- 5.4 Энэхүү журмыг хэрэгжүүлэлтийг даатгалын газар, хяналтыг санхүү бүртгэлийн газар, компанийн дотоод хяналтын менежер хариуцан ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд холбогдох ажилтанууд компанийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээнэ.

Даатгалын төлөөлөгч, зуучлагчид  
шимтгэл олгох журмын хавсралт №01

## ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ШИМТГЭЛ ОЛГОХ ЗӨВШӨӨРӨЛ

№	Байгууллагын нэр	Даатгалын төрөл	Даатгалын хураамжийн хэмжээ	Шимтгэлийн хувь	Шимтгэлийн хувь нэмэгдэх шалтгаан	Төлөөлөгчийн нэр	Хохирол нөхөлтийн харьцаа
1							
2							
3							

ДААТГАЛЫН МЭРГЭЖИЛТЭН:

.....

ЗӨВШӨӨРСӨН: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

О.ГАНТӨМӨР